**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/104/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 02 дугээр сарын 05 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 12
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 15
4.1 Ерөнхий зүйл ..... 15
4.2 Материаллаг байдал ..... 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
5.3 Зөвлөмж ..... 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.14 № 2/11

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Н.ШАГДАРСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 378,291.3 мянган төгрөг болж өмнөх оноос 207,556.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үндсэн үйл ажиллагааны давсан орлогын авлагаас 67,897.0 мянга, бусад эх үүсвэрээс 11,690.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл авсантай холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98.1 хувиар үнэлсэн байна.

005020133

D/2023-A4 Alban toot.doc

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot.doc

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **114,525,089.92** | **68,171,897.72** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,018,900.00 | 2,039,200.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 1,018,900.00 | 2,039,200.00 |
| **3121** | **Төгрөг** | 1,018,900.00 | 2,039,200.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 1,018,900.00 | 2,039,200.00 |
| **33** | **АВЛАГА** | 82,184,988.77 | 2,183,969.10 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 335,327.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 81,849,661.77 | 2,183,969.10 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 81,849,661.77 | 2,183,969.10 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31,321,201.15 | 63,948,728.62 |
| **351** | **Түүхий эд материал** | 19,386,856.15 | 25,386,396.29 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,000.00 | 9,328,325.00 |
| 35130 | Эм боох материал | 19,374,856.15 | 16,058,071.29 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 00.00 | 28,774,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 00.00 | 99,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 11,934,345.00 | 9,689,332.33 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,884,400.00 | 2,182,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,401,945.00 | 7,507,132.33 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 648,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **170,735,157.50** | **378,291,272.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 170,735,157.50 | 378,291,272.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 135,185,157.50 | 342,576,272.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 127,029,515.90 | 125,472,171.96 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -14,059,316.10 | -14,592,837.60 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 47,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -3,570,000.03 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 27,319,700.00 | 179,789,376.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18,333,491.80 | -10,013,501.63 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,240,376.62 | 23,148,439.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,103,293.88 | -8,115,708.73 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -408,333.24 | -641,666.52 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,810,000.00 | 00.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,810,000.00 | 00.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 35,550,000.00 | 35,715,000.00 |
| 39301 | Програм хангамж | 896,000.00 | 1,061,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -896,000.00 | -896,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 35,550,000.00 | 35,550,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **285,260,247.42** | **446,463,170.47** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **478,516.28** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 478,516.28 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 478,516.28 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 478,516.28 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **284,781,731.14** | **446,463,170.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 284,781,731.14 | 446,463,170.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 96,568,996.01 | 96,568,996.01 |
| 51101 | Өмч: - төрийн | 96,568,996.01 | 96,568,996.01 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 134,099,931.44 | 304,455,475.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 134,099,931.44 | 142,774,036.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 161,681,439.33 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 54,112,803.69 | 45,438,699.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **285,260,247.42** | **446,463,170.47** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **398,937,005.00** | **557,226,688.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **172,869,585.00** | **528,348,388.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **172,869,585.00** | **528,348,388.26** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **172,234,085.00** | **333,810,565.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 172,234,085.00 | 331,773,565.00 |
| 120009 | Бусад орлого | - | 2,037,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 182,857,308.26 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 635,500.00 | 11,680,515.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **226,067,420.00** | **28,878,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **121,755,500.00** | **26,658,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 121,755,500.00 | 26,658,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **104,311,920.00** | **2,220,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 104,311,920.00 | 2,220,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **317,696,147.31** | **395,545,248.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **317,696,147.31** | **395,545,248.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **234,595,252.31** | **272,017,888.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **148,628,423.83** | **158,185,113.53** |
| 210101 | Үндсэн цалин | 126,736,572.76 | 124,254,296.53 |
| 210102 | Нэмэгдэл | 15,596,798.80 | 25,720,374.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,647,251.27 | 4,689,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,647,801.00 | 3,521,443.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **19,194,235.63** | **19,750,106.15** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,569,224.92 | 13,392,776.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,470,737.83 | 1,683,831.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,176,772.62 | 1,246,266.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 291,444.60 | 311,566.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,686,055.66 | 3,115,665.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,681,006.67** | **18,977,839.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,094,586.67 | 7,338,122.93 |
| 210302 | Түлш, халаалт | 8,365,500.00 | 8,185,597.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,220,920.00 | 3,454,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,347,386.78** | **15,054,759.84** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,595,501.00 | 2,889,822.67 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,874,200.00 | 4,771,137.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,792,513.05 | 2,414,021.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 30,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,055,172.73 | 2,241,648.67 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 2,738,130.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **14,683,814.36** | **18,583,215.58** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 14,683,814.36 | 18,583,215.58 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **16,316,890.38** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,646,890.38 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,110,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 13,560,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,247,600.00** | **6,201,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,247,600.00 | 6,201,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,286,848.00** | **2,154,870.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,145,048.00 | 1,100,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 128,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 109,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 60,270.00 |
| 210807 | Газрын төлбөр | 141,800.00 | 142,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 614,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,525,937.04** | **16,793,893.01** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 591,600.00 | 685,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 621,692.00 | 1,518,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,312,645.04 | 14,589,193.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **83,100,895.00** | **123,527,360.51** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **83,000,000.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 83,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **36,333,900.00** | **3,416,146.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,073,900.00 | 2,932,546.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 260,000.00 | 483,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **46,766,995.00** | **37,111,214.51** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,766,995.00 | 37,111,214.51 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **81,240,857.69** | **161,681,439.33** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **81,240,857.69** | **161,681,439.33** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **409,348,827.00** | **416,245,126.77** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **173,252,985.00** | **333,814,165.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **173,252,985.00** | **333,814,165.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **172,234,085.00** | **331,773,565.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 172,234,085.00 | 331,773,565.00 |
| 120009 | Бусад орлого | 1,018,900.00 | 2,040,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **236,095,842.00** | **82,430,961.77** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **121,755,500.00** | **26,658,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 121,755,500.00 | 26,658,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **114,340,342.00** | **55,772,661.77** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 114,340,342.00 | 55,772,661.77 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **401,648,627.00** | **367,624,826.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **401,648,627.00** | **367,624,826.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **269,597,039.33** | **241,913,497.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **148,658,639.55** | **158,290,415.20** |
| 210101 | Үндсэн цалин | 126,777,541.00 | 125,090,211.85 |
| 210102 | Нэмэгдэл | 15,596,801.35 | 25,720,374.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,636,496.00 | 4,689,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,647,801.20 | 2,790,829.35 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **20,028,948.11** | **19,787,993.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,175,735.63 | 14,183,158.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,470,737.70 | 1,407,508.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,176,590.12 | 1,119,286.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 291,444.58 | 279,821.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,914,440.08 | 2,798,217.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,471,696.29** | **18,977,839.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,885,276.29 | 7,338,122.93 |
| 210302 | Түлш, халаалт | 8,365,500.00 | 8,185,597.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,220,920.00 | 3,454,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,540,189.05** | **7,488,896.17** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,388,326.00 | 1,470,522.67 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,522,200.00 | 2,865,824.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,799,663.05 | 2,394,221.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 30,000.00 | 0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 758,328.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **11,818,700.00** | **13,495,726.43** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,818,700.00 | 13,495,726.43 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0** | **9,115,350.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 2,045,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 1,376,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 0 | 5,693,950.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,247,600.00** | **7,292,513.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,247,600.00 | 7,292,513.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **60,341,449.33** | **3,436,662.67** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 59,689,649.33 | 2,238,692.67 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0 | 128,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0 | 109,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0 | 60,270.00 |
| 210807 | Газрын төлбөр | 141,800.00 | 136,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0 | 6,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 510,000.00 | 758,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,489,817.00** | **4,028,100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,660,000.00 | 3,241,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 829,817.00 | 786,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **132,051,587.67** | **125,711,329.61** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0** | **83,000,000.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0 | 83,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **36,333,900.00** | **3,416,146.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,073,900.00 | 2,932,546.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 260,000.00 | 483,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **95,717,687.67** | **39,295,183.61** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,766,995.00 | 37,111,214.51 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 48,950,692.67 | 2,183,969.10 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **7,700,200.00** | **48,620,300.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **6,681,300.00** | **47,600,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,681,300.00** | **47,600,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **6,681,300.00** | **47,600,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,681,300.00 | 47,600,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-6,681,300.00** | **-47,600,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **1,018,900.00** | **1,020,300.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 1,018,900.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,018,900.00 | 2,039,200.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 96,568,996.01 | 54,112,803.69 | 52,859,073.75 | 203,540,873.45 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 96,568,996.01 | 54,112,803.69 | 52,859,073.75 | 203,540,873.45 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 81,240,857.69 | 81,240,857.69 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 96,568,996.01 | 54,112,803.69 | 134,099,931.44 | 284,781,731.14 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 96,568,996.01 | 54,112,803.69 | 134,099,931.44 | 284,781,731.14 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 8,674,104.60 | 8,674,104.60 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 96,568,996.01 | 54,112,803.69 | 142,774,036.04 | 293,455,835.74 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -8,674,104.60 | 0 | -8,674,104.60 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 161,681,439.33 | 161,681,439.33 |
| 20 | 2022 оны 06-р сарын 30-наарх үлдэгдэл | 96,568,996.01 | 45,438,699.09 | 304,455,475.37 | 446,463,170.47 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 238,899,500.00 | 238,320,650.49 | 578,849.51 | 99.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 238,899,500.00 | 238,320,650.49 | 578,849.51 | 99.76 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 235,482,900.00 | 234,904,504.49 | 578,395.51 | 99.75 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 158,304,500.00 | 158,290,415.20 | 14,084.80 | 99.99 |
| 210101 | Үндсэн цалин | 110,598,100.00 | 125,090,211.85 | - 14,492,111.85 | 113.10 |
| 210102 | Нэмэгдэл | 42,624,400.00 | 25,720,374.00 | 16,904,026.00 | 60.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,082,000.00 | 4,689,000.00 | 393,000.00 | 92.27 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 2,790,829.35 | -2,790,829.35 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,788,000.00 | 19,787,993.76 | 6.24 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,455,900.00 | 14,183,158.56 | -727,258.56 | 105.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,583,000.00 | 1,407,508.80 | 175,491.20 | 88.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,266,400.00 | 1,119,286.95 | 147,113.05 | 88.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 316,600.00 | 279,821.85 | 36,778.15 | 88.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,166,100.00 | 2,798,217.60 | 367,882.40 | 88.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,365,400.00 | 18,977,839.93 | 387,560.07 | 97.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,314,000.00 | 7,338,122.93 | -24,122.93 | 100.33 |
| 210302 | Түлш, халаалт | 8,628,400.00 | 8,185,597.00 | 442,803.00 | 94.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,423,000.00 | 3,454,120.00 | -31,120.00 | 100.91 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,344,600.00 | 7,226,323.5 | 118,276.5 | 98.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,137,800.00 | 1,207,950.00 | -70,150.00 | 106.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,876,000.00 | 2,865,824.00 | 10,176.0 | 99.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,383,300.00 | 2,394,221.50 | -10,921.50 | 100.46 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 947,500.00 | 758,328.00 | 189,172.00 | 80.03 |
| **2105** | **Нормативт зардал** | 10,008,300.00 | 10,008,299.10 | 0.90 | 100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,008,300.00 | 10,008,299.10 | 0.90 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,115,400.00 | 9,115,350.00 | 50.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,415,000.00 | 2,045,000.00 | 370,000.00 | 84.68 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,006,400.00 | 1,376,400.00 | -370,000.00 | 136.76 |
| 210604 | Урсгал засвар | 5,694,000.00 | 5,693,950.00 | 50.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,292,600.00 | 7,292,513.00 | 87.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,292,600.00 | 7,292,513.00 | 87.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,256,300.00 | 1,197,970.00 | 58,330.00 | 95.36 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 128,000.00 | 128,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 116,200.00 | 109,500.00 | 6,700.00 | 94.23 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 77,200.00 | 60,270.00 | 16,930.00 | 78.07 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 26,000.00 | 00.00 | 26,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 136,000.00 | 136,000.00 | 0.00 | 100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 14,900.00 | 6,200.00 | 8,700.00 | 41.61 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 758,000.00 | 758,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,007,800.00 | 3,007,800.00 | 0.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,221,400.00 | 2,221,400.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 786,400.00 | 786,400.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3416600.00 | 3416146.00 | 454.00 | 99.99 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,416,600.00 | 3,416,146.00 | 454.00 | 99.99 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 2,933,000.00 | 2,932,546.00 | 454.00 | 99.98 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 483,600.00 | 483,600.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 238,899,500.00 | 275,431,865.00 | 36,532,365.00 | 99.7 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 26,658,300.00 | 26,658,300.00 | 0.00 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 26,658,300.00 | 26,658,300.00 | 0.00 | 100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 212,241,200.00 | 248,773,565.00 | 36,532,365.00 | 99.7 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 212,241,200.00 | 248,773,565.00 | 36,532,365.00 | 99.7 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 13 | 13 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2 | 2 | 0.00 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | 13 | 13 | 0.00 | 100.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 4 | 4 | 0.00 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 8 | 0.00 | 100.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **114340342.00** | **5,992,292.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **114340342.00** | **5,992,292.67** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 114340342.00 | 5,992,292.67 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 262,572.67 |
| 210401 | Бичиг хэрэг | | 262,572.67 |
| **2105** | **Нормативт зардал** | | 3,487,427.33 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 3,487,427.33 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 114340342.00 | 2,242,292.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 114340342.00 | 2,242,292.67 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **47,600,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 47,600,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 47,600,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 114340342.00 | 2220000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 114340342.00 | 2,220,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 114340342.00 | 2,220,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь "Бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэмжүүр хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулга, стандарт түгээлт, сургалт сурталчилгаа, үнэт метальд сорьц тогтоох үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй.

Тус байгууллага нь аймаг орон нутгийн хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүйн, тохирлын үнэлгээ, сорцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд улсын хэмжээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алтны сорьцын лаборатори ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний дотоод хяналт, шалгалтын хэлтэс дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Стандарт, хэмжил зүйн газраас баталсан салбарын "Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг" нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 446,463.2 мянган төгрөг болж өмнөх оноос 161,202.9 мянган төгрөгөөр буюу 56.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,018.9 | 2,039.2 | 1,020.3 |
| Авлага | 82,185.0 | 2,184.0 | -80,001.0 |
| Бараа материал | 31,321.2 | 63,948.7 | 32,627.5 |
| Үндсэн хөрөнгө | 219,345.6 | 416,121.0 | 196,775.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | -48,610.4 | -37,829.7 | 10,780.7 |
| **Нийт хөрөнгө** | **285,260.2** | **446,463.1** | **161,202.9** |
| Өр төлбөр | 478.5 | 0.0 | -478.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 284,781.7 | 446,463.2 | 161,681.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **285,260.2** | **446,463.2** | **161,202.9** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,039.2 мянган төгрөг болж өмнөх 1,020.3 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын санд оны эцэст мөнгө төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 2,184.0 мянган төгрөг болж өмнөх оноос 80,001.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үйл ажиллагааны давсан орлого буцаан төвлөрүүлснээс үүссэн авлага 48,950.7 мянга, хөрөнгө бэлтгэх, ажил гүйцэтгэхээр мөнгийг шилжүүлж хөрөнгө аваагүйгээс 28,297.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байсныг тайлант онд барагдуулсантай холбоотой бөгөөд оны эцэст улсын төсөвт 2,184.0 мянган төгрөг төвлөрүүлж санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63948.7 мянган төгрөг болж өмнөх оноос 32,627.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 24,309.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 40,454.5 мянга бүгд 64,763.5 мянган төгрөгийн орлого авч 32,136.0 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Энэ нь аймгийн орон нутгийн төсвөөс Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын гадна засварыг 28,774.0 мянган төгрөгөөр хийж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын шийдвэр гараагүйтэй холбоотой дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд залруулсан, Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11,463.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирснийг тусгай зориулалтын материалд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 378,291.3 мянган төгрөг болж өмнөх оноос 207,556.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 165.0 мянган төгрөгийн программ хангамжийн сайжруулалт хийсэн, өмнөх оны үндсэн үйл ажиллагааны давсан орлогын авлагаас 47,600.0 мянган төгрөгийн технологийн машин, урд оны санхүүгийн аудитын залруулгаар хөрөнгө бэлтгэх мөнгийг шилжүүлж хөрөнгө аваагүй авлага үүсгэсэнтэй холбоотой 20,297.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, СХЗГ-ын даргын 2022.11.23-ны өдрийн А/197 дугаар тушаалаар 11,690.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, ТӨБЗГ-ын 2022.12.27 өдрийн 657 дугаар тогтоолоор 21,174.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтыг сунгаж 10,610.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосонтой холбоотой байна. Мөн ТӨБЗГ-ын 2022.12.27-ны өдрийн 705 дугаар тогтоолоор 4,961.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Тайлант оны эхэнд 478.5 мянган төгрөгийн өглөгтэй байсан оны эцэст өглөггүй байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 446,463.2 мянган төгрөг болж 161,681.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 161,681.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 312,632.1 мянга, нийт зарлагыг 312,632.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 102,238.1 мянган төгрөгөөр бууруулж 210,394.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 238,899.5 мянган төгрөг болгож 28,505.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70407 хөтөлбөрийн 80101, 80802, арга хэмжээг санхүүжүүлэхээр 238,899.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 26,658.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 212,241.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 26,658.3 мянга, үндсэн үйл ажиллагааны 331,773.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 83,000.0 мянган төгрөгийн орлогыг СХЗГ-ын 1009000009012 тоот дансанд, оны эцэст 37,111.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 238,320.6 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 578.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71804 Стандартчилал хэмжил зүй** | **238,899.5** | **238,320.6** | **578.9** | **99.7** |
| 2 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 235,482.9 | 234,904.5 | 578.4 | 99.7 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 3,416.6 | 3,416.1 | 0.5 | 100 |
| | **Нийт дүн** | **238,899.5** | **238,320.6** | **578.9** | **99.7** |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030009401 тоот дансанд 55,772.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж ТӨБЗГ-ын 100900000703 тоот дансанд түрээсийн орлогын 40 хувь болох 888.0 мянган төгрөг төвлөрүүлж, оны эцэст улсын төсөвт 2,184.0 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар тусгасан байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төгрөгөөр/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Түрээсийн орлого | 2,220.0 |
| 2 | Өмнөх оны давсан орлого | 48,950.7 |
| 3 | Өмнөх оны авлага | 4,602.0 |
| | Нийт орлогын дүн | 55,772.7 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 21-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Шагдарсүрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баярмаа нар зурж байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 238,899.5 мянган төгрөгөөс 3,583.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 2,508.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүтэн жил | 11 | 11 | 5 | 4 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 34 | 2 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 88 | 8 | |
| | Нийт | 27 | 151 | 134 | 15 | 2 |

Тус байгууллага нь 2022 онд нийт 255184.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11 мэдээлэл хугацаа хоцроож, 4 мэдээлэл байршуулаагүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 120,111.2 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 123,469.7 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 28,297.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,058.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа, зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, дээд байгууллагаас ирүүлсэн чиглэлийг мөрдөн ажиллах 90,114.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын 2022.09.29-ны өдрийн 119 дүгээр албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 3 | 5,058.0 | 3 | 5,058.0 | 100 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 3 | 90,114.7 | 3 | 90,114.7 | 100 |
| **Нийт дүн** | **6** | **95,172.7** | **6** | **95,112.7** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын явцад тус байгууллага нь аймгийн МХГ-ын байранд нүүж орон үйл ажиллагаа явуулж байгаа ба тус байгууллагын зарим хөрөнгө, аж ахуйн материал бүртгэлээр шилжүүлж байгаа тул гүйцэтгэлийг энэ аудитад хамруулан шалгаагүй завсрын аудитаар үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,774.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 28,774.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулла.

1.Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай" 2022/138 дугаар гэрээний 9.2.1 дэх заалтын дагуу Стандарт хэмжил зүйн газрын гадна засварыг "Алтайн гурван нуур" ХХК-тай шууд гэрээ байгуулан 28,774,0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Байгууллагын барилгын гадна засварын ажил хүлээлцэх комиссыг байгууллагын даргын 2022.08.15-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулан ажлыг хүлээн авсан байна. Харин аймгийн ИТХ-ын шийдвэр гараагүй байхад нягтлан бодогч барилгын өртгийг 28,774.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3. "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчиж байгаа тул үндсэн хөрөнгөөс хасаж бараа материалыг нөөц дансанд бүртгэж санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар нийт 1,478.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,478.4 мянган төгрөгийн алдааг давтан гаргахгүй зөвлөмж хүргүүллээ.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Түлш халаалтын зардлаас 2022.12.23-д МТ. Сонгинохайрхан ХХК руу бензин шатахууны үнэнд 387.1 мянган төгрөгийг андуурч гүйлгээ хийсэн бөгөөд аудитын явцад хэлбэлзлийг зассан, албан томилолтын зардлаас 2022.12.15-д НИК ХХК руу бензин шатахууны үнэнд 1,091.3 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын Түлш халаалт (210302) ангиллын зардлыг зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>*** Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан эдийн ангиллын дагуу зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

## Нийцлийн аудиттай холбоотой асуудал

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

*<u>Илрүүлэлт</u>:* Тус байгууллага нь 2022 онд нийт 255184.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11 мэдээлэл хугацаа хоцроож, 4 мэдээлэл байршуулаагүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 мэдээллийн 120,111.2 мянган төгрөг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>:*** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг үнэн зөв мэдээлж байх.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СХЗХ-ийн гадна засварын ажлыг капиталжуулах шийдвэр гараагүй байхад орлого авсан байна. | 1 | 28,774.0 | | | 1 | 28,774.0 | 1 | 28,774.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 28,774.0 | | | 1 | 28,774.0 | 1 | 28,774.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Түлш халаалтын зардлаас 387.1 мянга, томилолтын зардлаас 1,091.3 мянган төгрөгийн шатахууны зардалд зарцуулсан байна. | 1 | 1,478.4 | | | | | 1 | 1,478.4 | | | | |
| Нийт дүн | 1 | 1,478.4 | | | | | 1 | 1,478.4 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |

ooOoo